



**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ**

**“СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ САН”-Д ХИЙСЭН
ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ**

Шалгалт эхэлсэн:

2025 оны 08 дугаар сарын 11

Шалгалт дууссан:

2025 оны 08 дугаар сарын 30

Улаанбаатар хот

2025 он

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

“Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан”-д
дотоод хяналт шалгалт хийсэн тухай

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Шалгалтын зорилго

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас хийсэн “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан” (хуучин нэрээр Соёл, урлагийг дэмжих сан)-ийн санхүүгийн хяналт шалгалтаар өгсөн 2024 оны 04 дүгээр сарын 08-ний өдрийн Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 01/01-07, 01/01-07, 03/01-07 тус тус дугаартай “Журмын хэрэгжилтийг хангуулах тухай” 3 албан шаардлагын хэрэгжилтийг хангах зорилгын хүрээнд ССАЖЗЯ-ны Сайдын 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдөр баталсан удирдамжийн хүрээнд дотоод хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлээ.

1.2 Шалгалтын бүрэлдэхүүн хугацаа

Хяналт шалгалтыг 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдрөөс ажлын 5 хоногт Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга Д.Түмэндэмбэрэл ахалж, шинжээч Г.Шүрэндолгор нар хийж гүйцэтгэлээ.

1.3 Шалгалтад хамрагдсан асуудлууд

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Санхүүгийн ахлах байцаагчийн тавьсан 01/01-07, 02/01-07, 03/01-07 дугаар албан шаардлагад дурдагдсан асуудлуудыг хамрууллаа.

Хяналт шалгалтыг явуулахдаа Төсвийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжууд болон тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан тогтоол, шийдвэр, дүрэм, журамд үндэслэн илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, дахин давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах шийдвэрийг гаргаж, Санхүүгийн хяналт, шалгалтын стандартыг баримтлан улсын байцаагчийн эрх, үүргийн хүрээнд хяналт шалгалтыг явууллаа.

1.4 Өмнөх шалгалтын талаар

Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан СХШХ/01 дугаартай удирдамжийн хүрээнд “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан” (хуучин нэрээр Соёл, урлагийг дэмжих сан)-ийн 2023, 2024 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг 2025 оны 02 дугаар сард хийсэн байна.

Шалгалтаар 920,104.1 мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрч, шалгалтын явцад 133,599.8 мянган төгрөгийн зөрчил дутагдлыг арилгуулж, 3 зөрчилд албан шаардлага, цаашид авах арга хэмжээний 5 саналыг өгсөн байна.

ХОЁР. ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТААР ТОГТООГДСОН БОДИТ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Соёл, спорт, залуучуудын сайдын 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдөр баталсан удирдамжийн дагуу Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас хийсэн “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан” (хуучин нэрээр Соёл, урлагийг дэмжих сан)-ийн санхүүгийн хяналт шалгалтаар өгсөн 2024 оны 04 дүгээр сарын 08-ний өдрийн Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 01/01-07, 01/01-07, 03/01-07 тус тус дугаартай “Журмын хэрэгжилтийг хангуулах тухай” 3 албан шаардлагын хүрээнд дараах зөрчлийг хянан шалгалаа.

1. Сангийн яамны Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 01/01-07 дугаар албан шаардлагад **“Очирт хуур” ХХК нь 2024 онд “Соёлын биет бус өв болох баруун Монголын тууль, хөөмий, икэл хуур, товшуур хөгжмийг сурталчлан таниулах, ирээдүй хойч үедээ өвлүүлэн уламжлуулах” зорилготой “Очир эрдэнэ” төслийг хэрэгжүүлсэн гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн баримт ирүүлэхдээ төслийн санхүүжилтээс тус төсөлд хамааралгүй, зориулалт бусаар дизелийн түлшний төлбөрт 24,966.0 мянган төгрөгийг 2024 оны 12 дугаар 09-ний өдөр өөрийн эзэмшлийн Хаан банк дахь 5866192917 дугаартай данснаас “Өргөнбадрах далай” ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн и-баримтын ДДТД:1370555 дугаартай санхүүгийн төлбөрийн баримтыг хавсаргасан...”** гэсний дагуу шалгахад дараах нөхцөл байдалтай байна. Үүнд:

Очирт хуур ХХК-нь тус сангаас Ховд аймгийн Алтай, Булган, Үенч, Цэцэг, Дарви, Зэрэг, Манхан, Дөргөн, Мянгад, Эрдэнэбүрэн, Дуут, Жаргалант гэсэн 10 сумдад нийт 150 хүүхдэд хөөмий, икэл хуур, товшуур хөгжмийн сургалт заах, төслийн хүрээнд икэл хуур 38 ширхэг, товшуур хөгжим 36 ширхгийг хийж сургалтад суусан сурагчдад тараах 49,295.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Очир эрдэнэ” төслийн хэрэгжүүлэхээр 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр ССАЖЗЯ/24/197 дугаар гэрээг Соёл, спорт аялал, жуулчлал, залуучуудын яамны Төрийн бичгийн даргатай гэрээлсэн байна. Гэрээний урьдчилгаа 34,506.5 мянган төгрөгийн санхүүжилтийг 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр, үлдэгдэл санхүүжилт 14,788.5 мянган төгрөгийг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр тус тус төслийг хэрэгжүүлэгч Очирт ХХК-ний Хаан банкны 5866192917 дугаар дансанд шилжүүлсэн байна.

Очирт хуур ХХК-нь тус санхүүжилтээс 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Өрнөнбадрахдалай/РД-4074017/ ХХК-ийн Хаан банкны 5850090499 дугаар данс руу 24,966.0 төгрөгийг материалын үнэ, 1,805.4 мянган төгрөгийг шатахууны үнэ гэж тус тус шилжүүлсэн байна. Очирт нуур ХХК-нь Өрнөнбадрахдалай ХХК-аас түүхий эд материал худалдан авах, шатахууны жижиглэн худалдаа гэсэн 2 чиглэлээр ажил, үйлчилгээ авсан байна.

Худалдагч тал буюу Өрнөнбадрахдалай ХХК-ийг улсын бүртгэлийн нээлттэй мэдээллийн сангаас шалгахад:

- Аяллын операторын үйл ажиллагаа
- **Түүхий эд бэлтгэн нийлүүлэх**
- Хүнсний төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа
- Гадаад худалдаа
- Хуурай замаар хийгдэх ачаа тээвэр

-Шатахууны жижиглэн худалдаа гэсэн 6 чиглэлээр үйл ажиллагаагаа явуулах бүртгэлтэй, Ховд аймагт үйл ажиллагаагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байна.

Очирт хуур ХХК нь Өрнөнбадрахдалай ХХК -тай 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр худалдах, худалдан авах гэрээ хийсэн ба 4 метрийн урттай хушин банз 500 ширхгийг нийт 24,966.0 мянган төгрөгөөр худалдахаар гэрээлсэн. Худалдан авагч гэрээний төлбөрийг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор бүрэн төлж дуусахаар гэрээгээр тохиролцсон байна. Гэрээний хугацаанд төлбөрийг бүрэн барагдуулж 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр талууд гэрээгээ дүгнэж акт үйлдэж баталгаажуулсан байна. Худалдагч тал гэрээт ажлын ибаримтыг, бензин авсан баримттай адил утгаар шивж алдаа гаргасан байна. Тус баримтыг нягтлан шалгалгүй Төслийн тайлангийн баримтад хавсаргасан нь тухайн ажил гүйлгээг зориулалт бусаар зарцуулагдсан мэт буруу илэрхийлэл үүсгэсэн байна.

Шалгалтаар тус зөрчлийг арилгах арга хэмжээг авч төслийг хэрэгжүүлэгч Очирт нуур ХХК-д мэдэгдэж түүхий эд материал худалдсан байгууллагын гаргасан алдааг залруулах арга хэмжээг авч, буруу шивэгдсэн баримтын утгыг завсарлуулж материалын үнэ болгон ибаримтыг засварлууллаа. Мөн төсөл хэрэгжүүлэгчийн санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийн дутууг нөхөн баримтжуулж алдааг залрууллаа.

2. Сангийн яамны Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 02/01-07 дугаар албан шаардлагад **“Цогт тайжийн өргөө орд сан” ТББ нь 2023 онд “Цогт тайжийн Монгол нутаг дахь түүх, бичиг соёлын дурсгалын танилцуулга, сурталчилгааг виртуал технологи ашиглан хэрэгжүүлэх” төслийг хэрэгжүүлсэн гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн баримт ирүүлэхдээ 153.8 мянган төгрөгийн архи, согтууруулах ундаа худалдан авсан санхүүгийн баримт хавсаргасан**” гэх зөрчлийг шалгахад дараах нөхцөл байдалтай байна. Үүнд:

“Цогт тайжийн өргөө орд сан” ТББ нь 2023 онд “Цогт тайжийн Монгол нутаг дахь түүх, бичиг соёлын дурсгалын танилцуулга, сурталчилгааг виртуал технологи ашиглан хэрэгжүүлэх” төслийг хэрэгжүүлэхээр 38,700.0 мянган төгрөгийн өртөгтэй 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр СоЯ-23-128 дугаар гэрээг Соёлын яамны Төрийн бичгийн даргатай гэрээлсэн байна. Гэрээний урьдчилгаа 27,090.0 мянган төгрөгийн санхүүжилтийг 2023 оны 08 дугаар сарын 02-ны өдөр, үлдэгдэл санхүүжилт 11,610.0 мянган төгрөгийг 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдөр тус тус төслийг хэрэгжүүлэгчийн Хаан банкны 5132116645 дугаар дансанд шилжүүлсэн байна.

Төсөл хэрэгжүүлэгч “Цогт тайжийн өргөө орд сан” ТББ-ийн төслийн гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн баримтыг давтан нягтлан шалгахад 153.8 мянган төгрөгийн 4 удаагийн архи, согтууруулах ундаа худалдан авсан баримтыг хавсаргасан нь баримтаар нотлогдож байна.

Энэ нь Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т “Төрийн ёслол, хүндэтгэлийн гадаад арга хэмжээг зохион байгуулахаас бусад тохиолдолд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно” гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан

шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэснийг тус тус зөрчсөн байна.

3.Сангийн яамны Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 03/01-07 дугаар албан шаардлагад **“Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх төсөл арга хэмжээний саналыг хэлэлцэн дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн 8 гишүүн тус бүрд 500.0 мянган төгрөг, 2024 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хэлэлцэн дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн 3 гишүүнд тус бүр 500.0 мянган төгрөг нийт 5,500.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна”** гэснийг шалгахад дараах нөхцөл байдалтай байна.

Засгийн газрын 2020 оны 120 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих” журмын 2.3 дахь заалтад “Ажлын хэсэг нь соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон захиргааны байгууллага, соёл, урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус, мэргэжлийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 9 хүний бүрэлдэхүүнтэй байна” гэсний дагуу тус сангаас санхүүжүүлэх төсөл арга хэмжээг хэлэлцэн, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг 9 хүний бүрэлдэхүүнтэй бүрдүүлсэн байна.

Эдгээр гишүүдийн 2023 онд 5 гишүүн, 2024 онд 3 гишүүн нь төрийн бус, мэргэжлийн урлагийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүсээр гишүүдээ бүрдүүлсэн байна. Эдгээр гишүүд нь сангаас санхүүжүүлэх арга хэмжээний сонгон шалгаруулалт үйл ажиллагаанд шүүгчээр ажиллаж хөндлөнгийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлсэн байна. Эдгээр төрийн бус, мэргэжлийн урлагийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг гишүүд тус бүрд ажлын хөлс болох 500.0 мянган төгрөгийг 2023 онд “урамшуулал”, 2024 онд “шүүгчийн төлбөр” гэж тус тус шилжүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалт “Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно”, “Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих” журмын 5.1 дэх заалт “Сангийн хөрөнгөнөөс аливаа **татаас, урамшуулал, тусламж** олгохыг хориглоно” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Сангийн яамны Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 03/01-07 дугаар албан шаардлагаар өгсөн зөрчил нь нягтлан шалгахад үндэслэлтэй байна.

ДҮГНЭЛТ

Шалгалтаар Сангийн яамны Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн гаргасан албан шаардлагын дагуу шалгалт хийж, дараах арга хэмжээг авч ажиллалаа. Үүнд:

1. Сангийн яамны Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 01/01-07 дугаар албан шаардлагад дурдсан зөрчлийг шалгалтын явцад нотлох

баримтад үндэслэн буруу бичигдсэн ибаримтыг залруулж, дутуу анхан шатны баримтыг нөхөн бүрдүүлбэр хийлгэж, зөрчлийг арилгасан.

2. Сангийн яамны Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 02/01-07 дугаар албан шаардлагад дурдсан зөрчилд нөхөн төлбөрийн акт тавьж, буруутай этгээдээс актаар тогтоосон төлбөрийг барагдуулах арга хэмжээг авч, сангийн орлого болгож, зөрчлийг арилгуулав.
3. Сангийн яамны Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 03/01-07 дугаар албан шаардлагад дурдсан зөрчлийг хянан магадалж, “Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих” журамд ажлын хэсгийн зохион байгуулалтын ажлын зардал болон хараат бус шүүгч гишүүдээр ажиллаж байгаа ажлын хэсгийн хөндлөнгийн гишүүний ажлын хөлсийг олгох шаардлагатай гэж үзвэл журамд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг батлах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх зөвлөмж өглөө.

ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

1. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн сангаас санхүүжсэн арга хэмжээний гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн анхан шатны баримтыг сайтар нягталж, хүлээн авсны дараа гэрээг дүгнэх;

2. “Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих” журамд ажлын хэсгийн зохион байгуулалтын ажлын зардал болон хараат бус шүүгч гишүүдээр ажиллаж байгаа ажлын хэсгийн хөндлөнгийн гишүүний ажлын хөлсийг олгох шаардлагатай гэж үзвэл журамд нэмэлт өөрчлөлт оруулах;

3. Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.